



МАСКАА ЗҮҮЕ



ГАРАА УГААЯ



ЗАЙГАА БАРЬЯ



УСНЫ САЛБАРЫН ЭРГЭН ТОЙРОНД



Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№2 (09)

2021.03.01

“НӨХӨН СЭРГЭЭЛТ-2024” АРГА ХЭМЖЭЭГ ЭКОЛОГИЙН ЦАГДААГИЙН АЛБАТАЙ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛНЭ



БОАЖ-ын сайд Н.Уртнасан 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Экологийн цагдаагийн албаны удирдлагуудыг хүлээн авч уулзсан байна. Уулзалтаар байгаль орчноо хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлд хамтран ажиллах, иргэдэд экологийн боловсрол олгох, байгальд ээлтэй амьдрах талаар мэдээ, мэдээлэл тогтмол хүргэх зэрэг ажлыг хамтран хэрэгжүүлэх талаар ярилцаж, санал солилцжээ. Монгол Улсын Засгийн газар уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 8000 га талбайд нөхөн сэргээлт хийх ажлыг 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгагдсан. Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 30 гаруй мянган га талбайд нөхөн сэргээлт хийх шаардлагатай байгаа бөгөөд БОАЖЯ, Экологийн цагдаагийн албатай хамтран “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг энэ онд зохион байгуулахаар төлөвлөж бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна. Дашрамд дурдахад, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Экологийн цагдаагийн алба хамтран 2020 онд “Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд “Ой модоо хайрлая”, “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ирлээ явлаа цэвэр”, “Орчны бохирдлыг бууруулъя” зэрэг нөлөөллийн томоохон аянуудыг зохион байгуулсан нь давхардсан тоогоор 44 сая гаруй хүнд хүрчээ.

[Эх сурвалж: БОАЖЯ](#)

2030 УСНЫ НӨӨЦИЙН БҮЛГЭЭС ӨМНӨД ГОВИЙН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БҮСИЙН УСНЫ ЭРЭЛТ-ХАНГАМЖИЙН ГИДРОЭКОНОМИК ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАВ

МОНГОЛ УЛС | ӨМНӨД ГОВИЙН БҮС

ГИДРОЭКОНОМИК ШИНЖИЛГЭЭ:
МОНГОЛЫН ӨМНӨД ГОВИЙН УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БҮСИЙН УСНЫ ЭРЭЛТ-ХАНГАМЖИЙН ГИДРОЭКОНОМИК ШИНЖИЛГЭЭ



Дэлхийн Банкны дэргэдэх 2030 Усны Нөөцийн Бүлгээс Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны хүсэлтээр хийж гүйцэтгэсэн Монголын Өмнөд говийн уул уурхай, хүнд үйлдвэрийн бүсийн усны эрэлт-хангамжийн гидроэкономик шинжилгээний тайланг танилцуулав. Тайланг 2030 Усны Нөөцийн Бүлгийн Монгол дахь хөтөлбөрийн Олон Талт Оролцооны Платформын Удирдах Зөвлөлөөр хянаж, хүлээн зөвшөөрсөн байна. Тус тайлан нь 2030 Усны Нөөцийн Бүлгээс 2016 онд гаргасан гидроэкономик шинжилгээний дараагийн шатны судалгаа бөгөөд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050" баримт бичгийн хүрээнд боловсруулжээ. Тайланг дараах холбоосоор татаж үзэх боломжтой юм байна. Холбоос: <https://www.2030wrg.org/.../2030-WRG-Mongolia-HEA-Mining...>

[Эх сурвалж: Дэлхийн банкны албан ёсны фэйсбүүк хуудас](#)

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВӨӨС БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ ЦАХИМ ХИЧЭЭЛҮҮД ЦУВРАЛААР ХҮРГЭЖ БАЙНА



БОАЖЯ-ны харьяа, байгаль орчны холбогдолтой хууль тогтоомжийг олон нийтэд түгээх, экологийн боловсролыг бүх нийтэд олгох чиг үүрэг бүхий Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвөөс байгаль орчны боловсрол олгох цахим хичээлүүдийг албан ёсны фэйсбүүк хуудсаараа цувралаар хүргэж байна. Цахим хичээл 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс эхэлсэн бөгөөд одоогоор “Гол горхи, булаг шанд, Баян бүрд, нуур цөөрөм, рашаан зэрэг гадаргын усны талаар”, “Ус ашиглагч хэрэглэгч гэж хэнийг хэлэх вэ?, ус ашиглах, хэрэглэх зөвшөөрлийг хаанаас авах тухай”, “Гол нуур, далай тэнгисийн тухай”, түүнчлэн “Ахуйн хаягдлаа ангилан ялгах тухай”, “Хүнсний органик хог хаягдлаа хэрхэн ялгаж ангилах вэ?” гэсэн таван цуврал хичээлийг хүргээд байна.

[Эх сурвалж: Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв](#)

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- 2021 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар Төв цэвэрлэх байгууламж шинээр барих, Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц, Солонго-1 орон сууцны хороолол, Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам барих зэрэг томоохон төслийн явцыг эрчимжүүлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгалаа. [Эх сурвалж: Zasaq.mn](#)
- Улаанбаатар 2040 цахим хэлэлцүүлэг: Инженерийн бэлтгэл арга хэмжээ & Дэд бүтэц маргааш буюу 2021 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн 10.00 цагаас 13.05 цагийн хооронд болно. Хэлэлцүүлэгт оролцох хүсэлтэй хүмүүс <https://forms.gle/WD2EBMm1VYTQoeEF7> линкээр нэвтрэн мэдээллээ оруулах боломжтой. [Эх сурвалж: Хот тлгвллт хгжлийн институт](#)